

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016–2020 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ “ЭКО БҮРД–2020” ХӨТӨЛБӨР**

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Сумынхаа иргэн бүрт хүртээмжтэй, байгальд ээлтэй, ардын уламжлалт ёс заншилд нийцсэн, орчин үеийн шинжлэх ухаан технологийн ололтод суурилсан, өндөр өсөлттэй, өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэц бүхий ногоон эдийн засаг бүхий нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил дэвшилд хүрэхэд оршино.

Өвөрхангай аймгийн Бүрд сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “ЭКО-БҮРД-2020” хөтөлбөр /цаашид “хөтөлбөр” гэх/-ийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

дд	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2015 оны жилийн эцэс	Зорилтот түвшин 2019 оны эцэст
1	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт	Мян. төгрөг	192367,2	307000,0
2	Нийт бараа гүйлгээ	сая төгрөг	1012,0	1416,8
3	Иргэдийн мөнгөн хадгаламжийн хэмжээ	сая төгрөг	1658,0	
	Хүний тоо	тоо	2867	3000
4	Дундаж наслалт	жил	57,9	60
5	Ядуурлын түвшин	хувь		
6	Ажилгүйчүүдийн тоо	тоо	20	10
7	Шинээр бий болгосон ажлын байр / байнга/	тоо	6	20
8	Шинээр бий болгосон ажлын байр / түр/	тоо	24	200
9	Нийгмийн даатгалд хамрагдсан иргэд	Тоо	336	650
10	1000 амьд төрөлтөд нялхасын эндэгдлийн түвшин	Промиль	0	0
11	1000 амьд төрөлтөд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	Промиль	21,3	0
12	100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин	Промиль	0	0
13	Халдварт өвчний гаралт 10000 хүнд ноогдох	Промиль	52,3	26,1
14	Хамран сургалт /ЕБС/ тойрог	Хувь	99,1	99,5
15	Сум	Хувь	54,6	60
16	Хамран сургалт /СӨБ/	хувь	87,5	90
17	Их, дээд сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дундаж	оноо	529,8	530
18	Дотуур байрны хүүхдийн тоо	тоо	46	80
19	Мэргэжилтэй багш нарын тоо	тоо	21	25
20	Хураан авсан үр тариа га/ургац тн	тн	0/0	
21	Төмс	га/ургац тн	11/55	15/180
22	Хүнсний ногоо	га/ургац тн	3/6	8/30
23	Малын тэжээл	га/ургац тн	3/15	7/35
24	Нийт сүрэгт үхэр сүргийн эзлэх хувь	хувь	3	8
25	Малын халдварт өвчин болон паразит өвчний гаралт	Тоо	20	10
26	Суманд ирсэн жуулчдын тоо	хүн	0	5000
27	Хүний гараар тариалсан мод бутны тоо	ш	1855	10000
28	Ногоон байгууламж	га	1,2	5

29	Сум хөгжүүлэх сан / эргэн төлөлт /	Мян.төг	268192.8	300.000.0
30	Малжуулах төслийн хөрөнгө / эргэн төлөлт / 2016 оны байдлаар/	Мян.төг / хувь	56000/32,75	56000/80
31	Соёлын төвийн өөрийн орлого / өссөн дүнгээр/	Мян.төг	1120,0	8000,0
32	Соёлын төвөөр үйлчлүүлсэн үзэгчдийн тоо / өссөн дүнгээр	Хүний тоо	5276	32000
33	Соёлын төв, спорт зааланд зохион байгуулсан арга хэмжээ / өссөн дүнгээр	тоо	76	400
34	Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	15	10
35	Гэмт хэрэг үйлдэгчдийн тоо	тоо	14	11
36	Гэмт хэрэг илрүүлэлт	Хувь	60	95
37	Өвс тэжээлийн фондын нийт хөрөнгө	Мян. Төг	15000	20000

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дугаар тогтоолоор “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ыг баталж ядуурлын бүх төрлийг эцэс болгох, дундаж наслалтыг 78-д хүргэх, нийт хүн амын 80% нь чинээлэг, дундаж давхаргад шилжих, ногоон хөгжлийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 оронд багтах зэрэг томоохон зорилтуудыг тавьсан юм.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлагдсан

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 09 сарын 28 өдрийн 2/01 дугаар тогтоолоор Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай” хөтөлбөрийг баталсан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 сарын 16 өдрийн хуралд Бүрд аймгийн Засаг даргын “ЭКО-БҮРД 2020” 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан оруулж байна.

Бүрд сумыг 2014-2024 онд хөгжүүлэх сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан эдийн засгийн урт хугацааны бодлого, стратегид хүрэхэд эн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай дунд хугацааны зорилго, зорилтуудыг уг хөтөлбөрт тусгав.

ТУЛГУУР БАРИМТ БИЧИГ

- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020
- Аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг
- Өвөрхангай аймгийн Засаг Даргын Бүтээлч Өвөрхангай -2020
- Өвөрхангай аймгийн Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр
- Бүрд сумын сумын хөгжлийн төлөвлөгөө 2014-2024
- Бүрд сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр
- Сумын төсөвт байгууллагууд, малчид, иргэд сонгогчдын санал
- Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсээс гаргасан эмхтгэл - 2015. Бүрд сум

СУМЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН ТҮВШИН

1930 оны БНМАУ-ын ИХ Хурлын шийдвэрээр 1930 оны 11 сарын 09 ны өдрийн Засгийн газрын 37-р хурлаар 13 аймаг шинээр байгуулах болж энэ засаг захиргааны өөрчлөлтийн шийдвэрийг 1931 онд хэрэгжүүлж Архангай аймгийн Бүрд сумын нэртэйгээр Шийрийн Бүрд гэдэг газар байгуулагджээ.

Тус сум нь 1942 оны эхээр Баянхонгор аймаг шинээр байгуулагдахад Өвөрхангай, Архангай, Төв аймгийн зарим сумдыг хооронд нь шилжүүлэх болж 1942 оны 2 сард Өвөрхангай аймагт шилжжээ. Улмаар Өвөрхангай аймгийн Бүрд сум болон шилжин сумын төв нь Онгон уулын ар Их мухарт суурьшсан байна.

Монгол Улсын хүйс нутаг Бүрд сум нь Өвөрхангай аймгийн нутгийн зүүн хойд хэсэгт хойт өргөрөгийн 47 хэм. зүүн уртрагийн 104⁰ хэмийн солбицолд 258,6 мянган га талбай эзлэн, далайн түвшнээс дээш 1600 метр өндөрт, Хангайн нурууны Зүүн урд төгсгөл үзүүр үзэсгэлэнт Эрээн, Батхаан уулсын хоорондох өргөн уудам нутагт оршино.

Бүрд сум нь Өвөрхангай аймгийн Баян-Өндөр Есөн зүйл, Хархорин, Архангай аймгийн Хашаат, Булган аймгийн Рашаант, Төв аймгийн Эрдэнэсант сумуудтай хаяа нийлж, Арвайхээр

хотоос 136 км, Улаанбаатар хотоос 300 орчим км-д сумын төв “Онгон” байрлана. Улаанбаатар-Арвайхээрийн гол засмал зам Бүрдийн нутаг дээгүүр өнгөрдөг нь зам харилцаа, дэд бүтэц хөгжихөд чухал хүчин зүйл болсон төвийн эрчим хүчний системтэй өндөр хүчдэлээр холбогдсон юм.

Бүрд сум нь нийт 5 багтай. 2015 оны байдлаар 2867 хүн амтай, эдгээрийн 74% нь хөдөө амьдардаг. 832 өрхтэй, үүнээс хөдөөд 590 сумын төвд 242 өрх байна., хүйсийн харилцаа 51:49 тэнцвэртэй. Нийт хүн амын 58,0 хувь нь 15-54 насныхан, 29,0 хувь нь 15-аас доош насны хүүхдүүд, 13,0 хувь нь 55-аас дээш насны ахмадууд байна. Хүн амын нас хүйсийг суваргаас харахад 15-24 насны хүн ам харьцангуй их байгаа нь хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж байгааг харуулж байна. 1000 хүнд ноогдох төрөлт 8,1 буюу 2015 оны байдлаар 63 хүүхэд төрсөн байна. 2015 онд Өвөрхангай аймагт хүний дундаж наслалт 57,9 байгаа нь улсын дундажтай адил байгаа юм.

Хүн амын шилжилт хөдөлгөөн их байна. 2015 оны байдлаар авч үзвэл 22 хүн шилжин ирж 61 хүн шилжин явсан байгаа нь 1000 хүн тутамд 13 хүн шилжин ирж, 1000 хүн тутмын 21,3 нь шилжин явж байна гэсэн үг.

2015 онд сум 324788 мянган толгой малтай байгаагаас 89% бог мал (үүнд, ямаа 34%), 11% нь бод мал байна. Сумын нийт өрхийн 85 хувь нь малтай, эдгээрийн 86 хувь (нийт өрхийн 76%) дөрвөн улирлын турш мал сүргээ маллан амьдардаг. 2015 оны мэдээнээс үзэхэд сумын 72,7% малчин өрхийн 96,5 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 71% хувь нь гар утастай, 70,0 хувь нь телевиз үздэг, 51,0 % нь мотоцикльтой, 39% автомашинтай байна.

Нийгэм, эдийн засгийн хөгжилд гарсан эдгээр амжилт ололтын зэрэгцээ Өвөрхангай аймгийн Бүрд сумын байгаль, соёлын өвийг хойч үедээ уламжлан өвлүүлэх, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд тэнцвэртэй хөгжих тогтвортой хөгжлийн үзэл санааг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа дараах асуудлууд байгаа юм.

СУМЫН ХӨГЖИЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Энэхүү дунд хугацааны хөгжлийн баримт бичигт суманд тулгамдаж буй хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх стратегийн зорилгуудыг дэвшүүлэн ажиллахаар тусгав.

1. Экосистемийн доройтол, уур амьсгалын өөрчлөлтөд орж болзошгүй.

Тус суманд 324 гаруй мянган толгой малтай. Энэ нь цаашид бэлчээрийн доройтол, цөлжилт, ган зуд нүүрлэх, усны хомсдол, ой, зэрлэг амьтан багасахад нөлөөлж экосистемийн доройтол оруулах эрсдэлтэй. Иймд экосистемийн доройтол явагдаж байгаа үйл явцыг багасгах шаардлага эн тэргүүнд тавигдаж байгаа юм. Экосистемийн доройтолд орсон сумдын алдааг давталгүй хүн амын эрүүл мэндийн болоод байгалийн ургамал, мал ан амьтдад аюул учруулахаас урьдчилан сэргийлэх шаардлага гарч байна.

Мал аж ахуй, хөдөө аж ахуйгаас ихээхэн хамааралтай тус суманд байгалийн ган, зудны хохирлын хэмжээ иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байдаг. Зөвхөн ган зудын эрсдлийг авч үзэхэд 2000 болон 2010 оны зудад малын хорогдсон байдаг. 2010 оны зудад 68,8 толгой мал хорогдож байсан. Иймд сумын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн эрсдэлийг бууруулах, түүнд эдийн засаг нийгмийн хувьд дасан зохицох, даван туулах арга хэмжээг шат дараалан системтэй хийх шаардлага гарч байгаа юм. Иймд энэхүү хөтөлбөрт тухайн асуудлуудыг шийдвэрлэх зорилгуудыг дэвшүүллээ.

2. Үйлдвэржилт үйлчилгээ, дэд бүтцийн хөгжил сул.

Суманд худалдааны 4 дэлгүүр, 2 блок ний цех, цайны газраас өөр үйлдвэрлэл үйлчилгаа байхгүй. Сумын барилга байгууламж дэд бүтэц олон жил болж муудсан шинээр засвар үйлчилгээ хийгдээгүй Иймээс улсын чанартай томоохон хөрөнгө оруулалт, дэд бүтцийн төслийг татах, бизнесийн болон бүтээн байгуулалтын таатай орчин бүрдүүлэх явдал хөгжлийн зорилго болж байна

3. Малчид иргэдийн орлого буурч шилжилт хөдөлгөөн ихсэж байгаа байгаа

Малын гаралтай түүхий эдийн үнэ ханш буурч байгаагаас шалтгаалан малчид иргэдийн орлого өсөхгүй байна. Иймд малын ашиг шимийг өсгөх, чанар, бэлтгэн нийлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, малчдын орлогыг нэмэгдүүлэх асуудал чухал болоод байна. Орлого, ажилгүй иргэдийн шилжилт хөдөлгөөн их байна. Тус сум 1970 онд 2616 хүн амтай байсан бол 1990 онд 4481 хүн болж өссөн бол 1990 оноос хойш 2010 онд 3041 болж 2015 оны байдлаар 2867 хүн болж буурсан дүн байна.

Эдийн засгийг дэмжиж ажлын байр буй болгохоос гадна байгалийн аялал жуулчлалын боломж, экосистемийн зохистой менежмент хийж, ХАА-н салбарыг хөгжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлэх зорилго чухал юм.

4. Хамран сургалт, эрүүл мэнд соёлын үйлчилгээний хүртээмж чанар муу

Сургуулийн хүүхдийн тоо жилээс жилд буурч байна. 2010 онд 370 орчим байсан суралцагчдийн тоо 2015 онд 316 болтлоо буурсан байна. Дотуур байранд 2010 онд 83 сурч байсан бол 2015 онд 49 болтлоо багасчээ. Бага 0-5 насны хүүхдийн эндэгдэл 2012 онд 1, 2013 онд 1, 2014 онд 2, 2015 онд 1 тус гарсан байна. Эмнэлэгийн ажилтны ур чадвар сул, Соёлын төвийн үйл ажиллагаа тогтвортой биш. Мэргэжлийн боловсон хүчний хангалт байхгүй. Хамран сургалт, эрүүл мэнд соёлын үйлчилгээний хүртээмж чанарыг эрс сайжруулах зорилгуудыг дэвшүүлээ.

5. Иргэдийн оролцоо, бүртгэл-судалгаа, мэдээлэл- хяналтын тогтолцоо сул

Сумын хүн ам, малын бүртгэлжилт, тооллого, эд хөрөнгийн зарцуулалт ашиглалт хамгаалалт шаардлага хангахгүй байна. Малчид иргэдэд мэдээлэлийг хүргэх тэдний төрийн үйлчилгээний талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, иргэний үүрэг хариуцлагын тогтолцоог өндөр болгох, орон нутгийн сан, сум хөгжүүлэх сангийн хэрэгжилт сул

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

Энэхүү дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмаар ажиллана.

1. *Бусдаас илүү чадварлаг боловсон хүчин*
2. *Эрүүл биед саруул ухаан*
3. *Цагийн менежмент, хөдөлмөрийн бүтээмж*
4. *Төлөвлөлт үр дүнгийн хяналтын тогтолцоо*
5. *Зөвшилцлөл гэрээ хэлэлцээр, хариуцлага*
6. *Манлайлал, үлгэр жишээ, загвар*
7. *Хамтын ажиллагаа, түншлэл*
8. *Шинэ технологи, шинэчлэлийн бодлого*
9. *Ил тод байдал мэдээлэл, сурталчилгаа*

Зарчим бүхнийг удирдана. Биднээс гадна орших байгаль дэлхийн хууль бол зарчим бөгөөд үйл хөдлөлийн үр дагаварыг хянаж удирдаж байдаг. Өөрөөр хэлбэл зан байдлын үр дагаварыг зарчим удирдана. Энэ биднээс хамааралгүйгээр ажлын үр дүнд нөлөөлж үйлчилж байдаг зүйл.

Бусдаас илүү чадварлаг боловсон хүчин.

Ийм боловсон хүчингүйгээр бид аливаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төвөгтэй болно. Ажлын үр дүнд тэмүүлдэг, зорилгодоо гуйвшгүй шийдмэг ханддаг, ажлын өндөр чанар бүтээмж, стандартуудыг мөрдөж чаддаг мэргэжлийн чин хүсэл зорилготой, даруу тийм хэрэгцээт хүмүүс ажлыг авч явдаг үр дүнд хүрдэг. Цэгцтэй хүмүүс, цэгцтэй сэтгэлгээ, цэгцтэй үйлдэл нь бусдаас илүү байх боломжийг олгодог.

Зарчмыг хатуу чанд мөрдөж сахилга бат, мэргэжлийн соёлыг бүтээгч, эрх чөлөө, хариуцлага хоёроо ухамсарлаж чадсан боловсон хүчин л ажлаа хийж чадна. Өөрийг алдаа олж харж засч чаддаг, харилцааны соёлтой, ажлын чанар хурд, бүтээмж үр дүн өндөр чанарууд бол цэгцтэй илүү чадварлаг боловсон хүчний чанар юм.

Эрүүл биед саруул ухаан

Эрүүл мэнд бол ажлын амжилтын үндэс. Ажиллагсад, иргэд ард түмнийг эрүүл мэнд, түүний хөнөөгч хорт зуршлаас хамгаалах ажил чухал. Ажил архи хоёр нийлэхгүй. Хичнээн төгс үүсгэл санаачлага, хичнээн онцгой шилдэг хүмүүс энэ муу зуршлын дарлалд өртөж ажил амьдралаа алдаж байна даа.

Ийнхүү ажил алба ба архидалт нь гал ус, гэрэл сүүдэр мэт бие биенээ үгүйсгэдэг Нийгмийн бүтээн байгуулалтанд шууд заналхийлэгч архидалтын эсрэг үлгэр дууриалал болж архидан согтуурахыг зогсооно.

Цагийн менежмент, хөдөлмөрийн бүтээмж

Бидэнд ижилхэн 24 цаг оногддог. Хэн хэрхэн цагийг ашиглаж байгаатай байгаагаас амжилт үр дүн нь өөр өөр байна. Зүгээр суугчид зүүгүй цагтайгаа хол хоцордог бол ажил зөгийнүүд амжилтын өндөрлөгт аль хэдийн гарч чаддаг. Завгүй завгүй гээд гүйгээд байвал та зүгээр суугч л гэсэн үг. Цагийн хуваарьт оруулаагүй ажил үйлс бүтдэггүй. Юуг хийх нь хамгийн чухал, Хий дэмий зүйл цагаа үрэх нь хайран. Бүх хүчин зүтгэлийн 20 хувь нь л 80 хувийн үр дүн авчирдаг гэсэн хууль бий. Үүнийг 80/20-ы зарчим ч гэдэг.

Иймд өөрийн өдөр тутмын ажил үйлээ хянаж, ямарч ашиггүй цаг үрсэн зүйлийг таслан зогсоож гол үндсэн яг хийх ёстой ажилдаа хамаг эрч хүч, оюун ухаан, хөдөлмөр зүтгэлээ, цагийн хуваариа зориулах хэрэгтэй. Тэр үед та амжилтанд хүрнэ. Зүгээр суугчид зүүгүй цаг. Хий дэмий интернет ухаж, чалчаа ховь хөөж, гадуур зорилгогүй сэлгүүцэж, бусдын хайран цагийг үрэн өрөө хэсэж, өглөө ажилдаа хоцорч, болзсон цагаасаа хоцорч, хүлээлгэж, хэл сураггүй алга болж, ажлын цагаар амин хувийн ажлаа элдэж хөөж хариулж, эмхэлж явахаа зогсоох учиртай.

Төлөвлөлт үр дүнгийн хяналтын тогтолцоо

Завгүй байна гэдэг нь дутуу бодож, дутуу төлөвлөж, цагаа зөв хуваарилж чадаагүйнх. Хэмжиж судлаж бодож, төлөвлөж болсон юмыг удирдаж болно. Хийх гэж буй ажлаа аль нь чухал, юуг нь түрүүлж хийх вэ гэдгээ бодож төлөвлөхгүйгээр ажлаа эхэлж байгаа хүн амжилтанд хүрэхгүй.

Долоо хэмжиж нэг огтол гэдэгчлэн юу хийх ээ заавал тунгаан бодож төлөвлөх учиртай. Тэгвэл зөв чухал юм аа яаж тодорхойлох вэ? Болсон болоогүй олон юм хийж өөрийгөө зовоож, чанаргүй юм гаргахын оронд түр ажлаа зогсоогоод хамгийн чухал цөөхөн үндсэн ажилдаа анхаарлаа төвлөрүүлээд төлөвлөж ажилла. Төлөвлөлт хяналт хоёр салшгүй нэг багц зүйл.

Зөвшилцлөл гэрээ хэлэлцээр, хариуцлага

Харилцан ашигтай хэн нэгнийхээ хэрэгцээг хангасан байдлаар шийдвэр гаргах, гаргасан шийдвэртэй талууд сэтгэл хангалуун байж төлөвлөсөн ажлаа хамтран хийх зорилго нэгдэх нь ажлын амжилтын чухал хүчин зүйл мөн. Хэн нэгэн хүний биш илүү олон түмэнд ээлтэй илүү сайн арга зам шийдвэрийг сонгохын төлөө талууд зөвшилцөх учиртай.

Сайн харилцааны үр дүнд эргэцүүлэн бодож тунгаасан шийдвэрт зоримог хүрсний талаа гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж гэрээний эрх үүрэг хариуцлагаа ухамсарлана ажилладаг тогтолцоог бий болгоно.

Манлайлал, үлгэр жишээ, загвар

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэд, өрх айл, албан байгууллагуудын идэвхи санаачилга, бусдад үлгэр жишээ болох тэргүүн туршлага, манлайлал ихээхэн үүрэгтэй юм. Ялангуяа ядуурлыг бууруулах, байгаль хамгаалах, бэлчээрийн менежментийг зохистой хийх, орчны бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд байгууллага, хамт олон, хувь хүмүүсийн манлайлалыг дэмжих, нийтийн дунд алдаршуулан түгээх, загвар болгох, хэвлэл мэдээллээр сурталчилах зэрэг бодлогыг хэрэгжүүлнэ.

Хамтын ажиллагаа, түншлэл

Өөрийгөө хамгаалсан аминч харилцаанаас хүндэтгэлтэй харилцаанд улмаар хоршсон хамтарсан итгэл дүүрэн харилцаанд шилжихэд иргэд төрийн болон төрийн бус салбарын бүхий л төлөөлөл гол үүрэгтэй оролцоно учиртай

Энэ утгаараа малчдын бүлгээс эхлээд иргэний нийгмийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийг хувьд чадавхижуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх нь үр ашигтай хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэхэд чухал билээ.

Ялангуяа, байгууллагуудын ажилтнуудыг төрөл бүрийн сургалтад хамруулах, хөтөлбөрийн хэрэгжилтэд тэдгээр байгууллагын хувь нэмэр, үүрэг функцийг тодорхой болгох, санхүүгийн хувьд чадавхижуулахад ихээхэн анхаарч ажиллана

Шинэ технологи, шинэчлэлийн бодлого

Үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх, ХАА болон нийгмийн бүх салбарыг хөгжүүлэхэд шийдвэрлэхэд технологийн болон нийгмийн шинэлэг санаа, үр ашигтай шийдлүүд онцгой ач холбогдолтой.

Иймд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэд албан байгууллагуудын инноваци, шинэ технологийг дэмжиж, төрөл бүрийн урамшуулал, хөнгөлөлтийн механизмаар дэмжих стратегийг баримтална. Өөрийн цэцэрлэгээ цэвэр байлгахыг хүссэн хүн лууль шарилжинд ургах боломж өгдөггүй.

Ил тод байдал мэдээлэл, сурталчилгаа

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах дээрх бүх зарчмыг байнгын харилцаа, мэдээлэл, холбоогүйгээр гүйцэтгэх боломжгүй юм. Үүнд Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бусад түншлэгч талууд болон сумын иргэдэд тогтмол мэдээлэх, сурталчлах, тэдний санал шүүмжлэлийн мөрөөр хэрхэн ажилласнаа эргэн тайлагнах, харилцааны механизмыг бий болгож ажиллана.

Бодит үнэнийг ард түмнээсээ нууддаггүй үнэн сонсогдож байх орчныг бий болгоно.

Эдгээр ёсон зарчмыг үндсэн стратеги болгон мөрдөж дараах зорилго, зорилтуудыг 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр ажиллана.

ХӨТӨЛБӨРИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах **тэргүүлэх зорилгуудад** хүрнэ. Үүнд:

ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛГО 1. Байгаль орчныг хамгаалах, тэнцвэрт байдлыг хангах, нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, тогтвортой аялал жуулчлал, ногоон хөгжлийн цогц хөтөлбөр гарган, эко загвар сум бий болгох

Зорилт 1. *Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг дагуу хот байгуулалтын орчин үеийн эко хотхоны болон монгол үндэсний уран барилгын үзэл баримтлалаар боловсруулж хөгжүүлнэ.*

Зорилт 2. *Аялал жуулчлалыг сумын тэргүүлэх салбарын нэг болгон, Элсэн тасархай, Их бага Монгол, Ширээт цагаан нуур, Батхаан, Дуут манхан, Төв цэгээр аялах жуулчдын тоог өсгөж, жуулчдаас орох орлогыг нэмэгдүүлнэ*

Зорилт 2. *МАА-н салбарын эрсдэлийг бууруулах дасан зохицох арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх замаар байгалийн гамшигийн эрсдэлийг бууруулна.*

ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛГО 2. Хөдөө аж ахуй, хоёрдогч түүхий эд, барилгын үйлдвэржилтийг дэмжиж, аялал жуулчлалын бүс нутагт бүтээн байгуулалт хийж, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар малчид иргэдийн орлогыг өсгөж шилжилт хөдөлгөөнийг зогсооно.

Зорилт 1. *ХАА-н салбарын түүхий эдийг нэмүү өртөг шингээн ногоон технологиор боловсруулж, дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх*

Зорилт 2. *Түүхий эд боловсруулах болон барилгын материал, модон эдлэл, тавилга, талх нарийн боовны жижиг цехийг байгуулж ажлын байрныг нэмэгдүүлнэ.*

Зорилт 3. *Аялал жуулчлалын гол маршрутаар дэд бүтцийг хөгжүүлж, орон нутгийн аж ахуйн нэгж, нутгийн иргэдийн бизнест дэмжлэг үзүүлнэ*

ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛГО 3. Иргэдийн оролцоо, бүртгэл-судалгаа, мэдээлэл- хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж төрийн үйлчилгээний хамрах хүрээг эрс нэмэгдүүлж чанаржуулна

Зорилт 1. *Бүртгэл судалгаа, мэдээлэл хяналтыг тогтолцоог бий болгосноор иргэдийн оролцоо нэмэгдэж төрийн бодлого шийдвэрт тусгах, төрийн үйлчилгээг ил тод зохион байгуулах нөхцөл бүрдэнэ.*

Зорилт 2. *Сумын иргэдийн сурч мэдэх, боловсрох, соёлын үйлчилгээ, эрх зүйн тусламж авах эрхийг хангана.*

Зорилт 3. *Сумын иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй байлгана.*

ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛГОД ХҮРЭХ САЛБАРЫН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮРЭХ ҮР ДҮН

НЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО ЗОРИЛТУУД

САЛБАРЫН ЗОРИЛГО: Байгаль орчныг хамгаалах, тэнцвэрт байдлыг хангах, нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, тогтвортой аялал жуулчлал, ногоон хөгжлийн цогц хөтөлбөр гарган, эко загвар сум бий болгох ажлыг эхлүүлнэ.

1.1. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗРЫН ХАРИЛЦАА

Зорилт 1: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшигийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тогтолцоог бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшиг, цөлжилт, ган зуд, бэлчээрийн ургац, даац багтаамжийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор олгох
2. Цаг уурын сүлжээг өргөтгөн мэдээлэл түгээх тогтолцоог иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэх шинэ техник, технологи нэвтрүүлэх

Хүрэх үр дүн: Зориудаар нөлөөлсөн хур тунадасны хэмжээ нэмэгдэж, иргэдийн гамшигийн үед ажиллах мэдлэг болон мэдээлэл авах сүлжээ нэмэгдсэн байна.

Зорилт 2: Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалалтад авч, хур, тунадас, гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Усны нөөц, булаг шандны эхийг хамгаалж, усны мэдээллийн санг шинэчлэн, дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх
2. Төв суурин газрын хүн амыг баталгаат ундны усаар хангах эрүүл ахуйн бүс, дэглэмийг шинэчлэн тогтоож, тоолууржуулах

Хүрэх үр дүн: Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 20-иос доошгүй хувийг хамгаалалтад авч, гадаргын усны нөөц нэмэгдэн, ашиглалт сайжирсан байна.

Зорилт 3: Биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Батхаан, Эрээн уул, Монгол элс, бусад нутаг, сумын төвд ойжуулалт, мод үржүүлгийн ажил хийх мэргэжлийн байгууллага, иргэдийн санал санаачилгыг дэмжиж, ойн нөхөн сэргээлтийг эрчимжүүлэн, ойн хортон шавьжтай тэмцэх
2. Ойгоос мод шилжүүлэн суулгах журмын дагуу модыг сумын төвд газарт шилжүүлэн суулгах ажлыг зохион байгуулах
3. Сумын төвийн газрын ногоон байгууламжийг газар зохион байгуулалтын төлөвлөлтөд тусгах замаар хэмжээг одоогийн түвшингээс 2 дахин нэмэгдүүлэх
4. Хөгнө Тарнын Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа байгаль хамгаалагч улсын байцаагчтай хамтран ажиллах
5. Тогтвортой хөгжлийн боловсрол, түүний дотор байгаль орчинтой зүй зохистой харьцах боловсрол олгох, биологийн олон янз байдал, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын ач холбогдлыг таниулах асуудлыг мэргэжлийн болон төрийн бус байгууллага мөн насан туршийн боловсролын төвөөр дамжуулан сурталчлуулах, танилцуулах
6. Агаар, хөрс, усыг бохирдуулж байгаа эх үүсвэр, хаягдлын тооллого явуулж, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, хяналт шинжилгээг үр дүнтэй тогтмол болгох,
7. Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, хогийн цэгийг ландфилын аргаар дарах арга хэрэглэх

Хүрэх үр дүн: Экоосистемийн тэнцвэрт байдал хангагдаж, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

Зорилт 4: Газар зохион байгуулалтыг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Гэр хорооллын бүсэд дахин төлөвлөлт хийх замаар газар ашиглалтын нягтралыг сайжруулж, зохион байгуулалтыг оновчтой болгох
2. Иргэдийн амины орон сууцны зориулалтаар шинээр эзэмшүүлэх, өмчлүүлэх газарт төлөвлөлт хийх
3. Газар олголтыг иргэдэд ойлгомжтой, ил тод болгож, газар олгох үйл явцыг хялбаршуулах

Хүрэх үр дүн: Газрын төлөвлөлт оновчтой хийгдэж, олгох үйл явц ил тод, хялбар болсон байна.

1.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Зорилт 1. Аялал жуулчлалыг сумын тэргүүлэх салбарын нэг болгон, Элсэн тасархай, Их бага Монгол, Ширээт цагаан нуур, Батхаан, Дуут манхан, Төв цэгээр аялах жуулчдын тоог өсгөж, жуулчдаас орох орлогыг нэмэгдүүлнэ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, аялал жуулчлалын мэдээллийн төвийг байгуулна.
2. Ширээт цагаан нууранд “ӨНДӨР ГЭГЭЭНИЙ СҮМ” байгуулан гадаад дотоодын эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
3. Монгол улсын төв цэгт олон үндэстэн аймгуудын гэр музей, “ГАЛ ГОЛОМТОТ ТУСГААР ТОГТНОЛЫН ТАЛБАЙ” байгуулж үйл ажиллагааг эхэлүүлнэ.
4. Нүүдлийн соёл иргэншил, ахуй амьдралыг харуулсан аялал жуулчлалын эвент арга хэмжээ бий болгох зорилгоор Шарлингийн талд “МОНГОЛ НААДМЫН ЦОГЦОЛБОР” төсөл хэрэгжүүлнэ.
5. Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, ногоон шийдэлтэй үйлчилгээний газар, үдлэх-хоноглох газруудыг Шарлин, Хөөвөрт төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хөгжүүлэх
6. Шийрийн Бүрдний рашааныг эмчилгээний чанарын судалгааг хийлгэж рашаан, элсний хосолсон эмчилгээг бүхий эмнэлэг, амралт, ардын уламжлалт эмчилгээ, үйлчилгээний газруудыг бодлогоор дэмжиж, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлэх
7. Жуулчдад зориулсан бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, урлах, худалдаалах орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн жижиг дэлгүүр, худалдааны цэгийг байгуулах санал санаачилгыг дэмжиж ажиллана.

Хүрэх үр дүн: Аялал жуулчлалын маршрут, үзмэр нэмэгдэн, аялал жуулчлалын салбараас орох орлогыг өсгөж, гадаад дотоодын жуулчдын тоо суурь түвшингээс 2 дахин нэмэгдсэн байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

САЛБАРЫН ЗОРИЛГО: Мал аж ахуйн салбараас бусад салбарын ДНБ-ийг 2 дахин нэмэгдүүлнэ.

2.1. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

Зорилт 1: Сумын эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, ирээдийн амьжиргаатай уялдуулан сумын эдийн засгийг тэлэх бодлогыг авч хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, суманд хоршоо нөхөрлөл, аж ахуйн нэгжийг байгуулах санал санаачлагыг дэмжиж, орон нутгийнхны давуу эрхийг ханган, үр ашгийг бий болгох
2. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуйн зохистой орчинг бүрдүүлж, гадаад зах зээлд гаргах боломжийг судлан хэрэгжүүлж эхлэх
3. “Сумын эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлого”-ын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, “Бүрд сумын хэтийн зорилт, ногоон хөгжлийн бодлого”-ыг боловсруулж хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Гадаад, дотоодын нийт хөрөнгөө оруулалт нэмэгдсэн байна.

Зорилт 2: Сумын бие даан хөгжих эдийн засаг, төсөв санхүү, байгаль орчин, хүний нөөцийн эрх зүйн орчныг бий болгон хөгжүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Сумын бие даан хөгжих эдийн засгийн чиглэлийг тодорхойлж, бодлогын бичиг баримтад тусган хэрэгжүүлэх
2. Байгалийн нөөцийг зохистойгоор ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар сумын хөгжлийг дэмжих
3. Төсвийн тухай хуулийн хүрээнд сумын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг жил тутам нэмэгдүүлэх
4. Сумын орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг тодорхой, үр дүнтэй төсөл арга хэмжээнд зарцуулах чиглэлийг боловсруулж хэрэгжүүлүүлэх
5. Орон нутгийн нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

Хүрэх үр дүн: Сумын цаашид хөгжих хөгжлийн чиглэл тодорхойлогдож, бие даан хөгжих эдийн засаг, төсөв санхүү, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр жил тутам хуваарилагдсан хэмжээнээс нэмэгдсэн байна.

Зорилт 3: Өмчийн менежментийг сайжруулах, эдийн засгийн үр ашигтай өмчийг нэмэгдүүлж, төрийн болон орон нутгийн өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгож, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлэх
2. Төсвийн хөрөнгөөр хийгдэх барилга байгууламж, бараа, ажил үйлчилгээний төсөвт жишиг үнэ нормативт хэмжээг баримтлах, хийгдсэн ажлын чанарт хяналт тавьж, чанаргүй гүйцэтгэсний улмаас үүссэн хохирлыг нөхөн барагдуулах
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын төслийн санхүүжилт бий болсон болон хөрөнгүүдийн менежментийг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Өмчийн ашиглалт хамгаалалтын хяналт сайжирч, өмч эзэмшигчдийн хариуцлага дээшилнэ. Орон нутгийн өмчит болон хувийн хэвшлийн компаниудын нийгмийн ашигт ажиллагаа, хариуцлага, хамтын ажиллагаа нэмэгдэнэ.

Зорилт 4: Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтад дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдийг тэргүүнд дэмжих бодлогыг баримтлан, худалдан авах үйл ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, төрийн бус байгууллагын хяналт дор ил тод явуулах тогтолцоог бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтад дотоодын давуу эрхийг тооцож ажиллах
2. Орон нутгийн төсөв, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих худалдан авах ажиллагааны 30 хүртэл хувийг цахим хэлбэрээр зохион байгуулах
3. Төсөвт байгууллагуудад зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны 30 хүртэлх хувийг цахим хэлбэрээр зохион байгуулах
4. Тендер зохион байгуулагч болон тендер оролцогч компаниудыг чадавхижуулах сургалтанд хамруулах, боломжит бүхий л ажлуудыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, худалдан авах ажиллагаанд өрсөлдөөнийг бий болгох
5. Бүх шатны худалдан авах ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, хэрэгжиж буй ажлын гэрээний биелэлтэд хамтарсан ажлын хэсэг хүлээж авдаг тогтолцоог бий болгож, гэрээний хариуцлагыг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтаар дамжуулан дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод худалдан авалтыг явуулах тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 5: Төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, сумын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх албан даалгаварын хэрэгжилтийг улирал тутам тооцох замаар төсвийн алдагдлыг багасгах
2. Төсвийн ил тод байдлыг хангах замаар Шилэн дансанд мэдээллийг байршуулж буй эсэхэд тогтмол хугацаанд хяналт шалгалт явуулж, үр дүнг нийтэд мэдээлж байх
3. Сумын татварын орлогыг сар бүр төлөвлөгөөний дагуу тогтмол жигд биелүүлэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлж, орлого биелэлтийн үр дүнг сайжруулах

Хүрэх үр дүн: Төсвийн хэмнэж болохуйц зардлыг хасах замаар алдагдлыг багасгаж, сумдын орлого биелэлтийн үр дүнгээр санхүүжилтийг олгох хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 6: Татварын бүх төрлийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын баазыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжид зөвлөн туслах, мэдээлэл сургалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах
2. Орон нутгийн татварын баазыг нэмэгдүүлэх замаар төсвийн орлогыг одоо байгаа түвшингээс бууруулахгүй байх
3. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, салбар компаниудыг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгож, татварын орлогыг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Орон нутгийн татварын орлого жил бүр 10 хувиар өссөн байна.

Зорилт 7: Олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Нийгмийн бүх салбарт даатгалын системийг нэвтрүүлж, санхүүгийн түрээсийн талаар иргэдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх
2. Өрхийн болон хувь хүний санхүүгээ удирдах аргачлалыг бүх нийтэд түгээн хэрэгжүүлэх
3. Иргэдийн хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлэх талаар банкны салбартай хамтран ажиллах

Хүрэх үр дүн: Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх замаар иргэдийн хадгаламж өсөх, чанаргүй зээлийн тоо буурах, санхүүгийн бүтээгдэхүүнийг мэдээлэл, мэдлэг дээр үндэслэн зөвөөр сонгох чадавхи нэмэгдэнэ.

Зорилт 8: Сумын эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг тэргүүн ээлжинд хөгжүүлж, гадаад харилцааг эдийн засагжуулах бодлого баримтлан ажиллана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Япон, БНХАУ, БНСУ, Герман, ОХУ улсад сумын эдийн засгийг дэмжих орон тооны бус сайн дурын ажилтныг ТББ-ын төлөөллөөр хэрэгжүүлэх
2. “Бүрд бренд бүтээгдэхүүнийг”- аймгийн дэмжлэгтэйгээр БНХАУ-ын Эрээн хот, Эжиний хошуу, ОХУ-ын Улаан-Үдэ, Эрхүү хотуудад борлуулалт хийх,
3. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах төрөл бүрийн уулзалт, эвент арга хэмжээнүүдийг тогтмол авч хэрэгжүүлэх
4. ОУ-ын төсөл, хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлэх, шаардлагатай төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллах

Хүрэх үр дүн: Сумын эдийн засгийн хөгжилд гадаад, дотоод хамтын ажиллагааны оролцоо, үр ашиг нэмэгдсэн байна.

Зорилт 9: Сумын уламжлалт гадаад, дотоод харилцааг өргөжүүлэн, салбар хоорондын харилцааг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Сумын гадаад харилцааг аймгийн нэгдсэн бодлогод хамааруулж, гадаад хамтын ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор “Аймгийн гадаад харилцааны нэгдсэн бодлого” хөтөлбөрт хамрагдах
2. Аймгийн дэмжлэгээр сум, байгууллагууд гадаад орнуудын хот, муж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох

Хүрэх үр дүн: “Аймгийн гадаад харилцааны нэгдсэн бодлого” хөтөлбөрт сум орон нутгаа хамруулж, салбар хоорондын харилцааг уялдуулан хөгжүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх, хамтын ажиллагаа өргөжсөн байна

2.2. АЖ ҮЙЛДВЭР, БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт 1. ХАА-н салбарын түүхий эдийг нэмүү өртөг шингээн ногоон технологиор боловсруулж, дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Мал аж ахуйн түүхий эдэд түшиглэсэн арьс, шир, ноос, ноолуурыг уламжлалт технологи болон бага оврын тоног төхөөрөмж ашиглан боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг цех байгуулах
2. Махны чиглэлийн үүлдрийн мал өсгөх бодлогыг дэмжиж, мал нядалгааны цэг байгуулж, малын дотор дайвар бүтээгдэхүүнийг боловсруулж борлуулах жижиг үйлдвэр байгуулж малчдын мах борлуулах орлогыг нэмэгдүүлнэ.
3. Сүү боловсруулах цех байгуулж, малчид иргэдийн сүү, цагаан идээ боловруулж аймаг хотын зах зээлд гаргах идэвхийг дэмжиж ажиллана.
4. Хүнсний нарийн ногоо консервлох цех байгуулна.

Хүрэх үр дүн: ХАА-н үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2 дахин нэмэгдсэн байна.

Зорилт 2. Барилгын материал болон хөнгөн үйлдвэрлэлийн цех байгуулах санал санаачлагыг дэмжиж ажлын байрныг нэмэгдүүлнэ.

1. Түүхий эд хүлээн авах төвлөрсөн цэгтэй болох, хоёрдогч түүхий эд хүлээн авч ангилан ялгах цэгтэй болох
2. Барилгын материал, барилга засвар, замын алаг хавтан, өнгөлгөөний тоосго, чимэглэлийн баримал, блок үйлдвэрлэх санал санаачлагыг дэмжинэ.
3. Гэр ахуйн болон албан тасалгааны тавилга үйлдвэрлэлийг бий болгож бүтээгдэхүүний аймаг хотын зах зээлд гаргана
4. Талх, нарийн боовны цехийн тоог нэмэн үйл ажиллагааг өргөжүүлэх

Хүрэх үр дүн: Ажлын байр нэмэгдэж орон нутгийн байгууллага барилгын засвар тохижилт сайжирч үйлдвэрлэлийн орлого шинээр бий болно.

Зорилт 3. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг баталгаажуулах ажлыг зохион байгуулж, “ЭКО БҮРД БРЕНД” лого бүхий бүтээгдэхүүний цувралтай болно.

1. ХАА болон бусад үйлдвэрлэлийн салбарт бренд бүтээгдэхүүн бий болгох бодлого баримтлана.
2. Үйлдвэрлэгчдийн зах зээлийн судалгаа борлуулалтанд дэмжлэг үзүүлнэ.
3. Уламжлалт технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд борлуулах жижиг үйлдвэрлэлийг дэмжих
4. Нутгийн брэнд бүтээгдэхүүнийг баталгаажуулах ажлыг зохион байгуулж, “ЭКО БҮРД БРЕНД” лого зах зээлд таниулах арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх
5. Ашиглагдахгүй байгаа барилга объектуудыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эдийн засгийн эргэлтэнд оруулах

Хүрэх үр дүн: Бизнесийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлээр зохион байгуулсан төсөл, арга хэмжээний суурь түвшинг 3 дахин өсгөнө.

Зорилт 4. Сумын иргэдэд үйлчлэх бизнес хөгжлийн төвийг шинэ стандартыг дагуу шинэчлэн байгуулж тогтмол үйл ажиллагаатай болгоно.

1. Ахуй үйлчилгээний барилгыг бизнес хөгжлийн төвийн зориулалтаар завсарлах

2. Үйлчилгээний стандартын шаардлага хангасан үсчин гоо сайхны салон байгуулж ажиллуулах
3. Үйлчилгээний стандартын шаардлага гэрэл зураг гуталчны газартай болох
4. Үйлчилгээний стандартын шаардлага хангасан халуун ус, саун байгуулж ажиллуулах
5. Үйлчилгээний стандартын шаардлага хангасан хувцас засвар оёдлын газартай болох
6. Үйлчилгээний стандартын шаардлага хангасан автозасвар, граш, авто угаалгын газартай болох
7. Үйлчилгээний стандартын шаардлага хангасан гар утас засвар, цахилгаан болон электрон хэрэгслэлийн засварын газартай болох
8. Үйлчилгээний стандартын шаардлага хангасан худалдааны төвтэй болох
9. Үйлчилгээний стандартын шаардлага хангасан кафе зоогийн газартай болох

Хүрэх үр дүн: Сумын төвд үйлчилгээний стандартын шаардлага хангасан бизнес хөгжлийн төвтэй болж ажлын байр нэмэгдэнэ.

2.4.ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР

Зорилт 1. Байгаль цаг уурын нөхцөлд зохицсон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэн, бэлчээр ашиглалтыг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Сумын нийт мал сүргийн бүтцийг боловсронгуй болгож, үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх, чанартай малтай малчдыг урамшуулах, залуу малчдыг бэлтгэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөнгөвчлөхөд чиглэсэн бага оврын техник технологи нэвтрүүлэх.
2. Ферм хөгжүүлэхтэй холбогдуулан тэжээл үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех байгуулах
3. Бэлчээрийг бордох, олон наст ургамал тариалах, хашиж хамгаалах зэргээр бэлчээрийн ашиглалтын менежментийг сайжруулах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хийцтэй худаг шинээр барих, засварлах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн: Мал сүргийн чанар сайжирч, нэг малаас авах ашиг шимийн түвшинг 3-5 хувиар ахиулан, бэлчээрийн менежментийг сайжруулж, сумын аюулгүй нөөцийг өөрсдийн хүчээр бэлтгэнэ.

Зорилт 2. Мал амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний чанарыг сайжруулж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс болгох
2. “Аймгийн мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөр”-ийг суманд хэрэгжүүлж, мал эмнэлгийн тогтолцоог малчдын эрэлт шаардлагад нийцүүлэн, сумын нийт нутгийг мал амьтны гоц халдварт өвчингүй тайван байдлаа хадгалах
3. Малчид, мал бүхий иргэдээс ирүүлэх мал, амьтан халдварт өвчнөөр өвчилсөн сэжигтэй тохиолдлын үед дуудлагыг шуурхай мэдээлэх, мэдээллийг хүлээн авах сүлжээг бий болгож, дуудлага үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах
4. Жил бүр мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээг технологийн хугацаанд чанартай зохион байгуулж, голомтот нутгийн мал сүргийг бүрэн хамруулах

Хүрэх үр дүн: Халдварт болон гоц халдварт өвчин, мал амьтнаар дамжин халдварлах халдварт, гоц халдварт өвчнийг хяналтанд авснаар гоц халдварт өвчнөөр тайван байдлаа хадгалж, мах экспортлох боломжийг бүрдүүлэн малчдын орлого нэмэгдсэн байна.

Зорилт 3. Хоршоо, нөхөрлөл, малчны бүлэг зэрэг хөдөлмөрөө хорших санал санаачлагыг дэмжинэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Нөхөрлөл, хоршооны үйл ажиллагааг дэмжих талаар хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
2. Олон гишүүнтэй хамтын хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлж улмаар хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл- үйлчилгээг бий болгох байгуулах санаачлагыг дэмжих
3. Хоршоодыг зээлийн бодлогоор дэмжиж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөх, сургалтанд хамруулж, бүтээгдэхүүний борлуулах-зуучлах үйлчилгээ үзүүлж ашигтай ажиллах нөхцөлийг бий болгох

Хүрэх үр дүн: Эдийн засгийн болон менежментийн хувьд тогтворжсон хоршоо нөхөрлөл, малчны бүлгүүдийн тоо 2 дахин өссөн байна.

Зорилт 4. Хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, боловсон хүчний чадавхийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа мэргэжилтэй боловсон хүчний чадавхийг сайжруулах, дотоод, гадаад сургалтанд хамруулах
2. Цөөн малтай болон залуу малчдыг малжуулах төсөл хөтөлбөрт хамруулах, урамшуулах, чанартай малтай малчдыг дэмжих тогтолцоог бий болгох
3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөнгөвчлөхөд чиглэсэн бага оврын техник технологи нэвтрүүлэх
4. Малчдыг бэлтгэх, давтан сургах, мал аж ахуйн хөгжлийн талаарх гадаад, дотоодын туршлагыг судлах, нэвтрүүлэх
5. Малын хашаа, саравчийг шинэ төрлийн материалаар хийх бололцоог бүрдүүлж, хүртээмжийг сайжруулах

Хүрэх үр дүн: Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчний залгамж халааг бэлтгэж, дэвшилтэт техник технологи, тэргүүн туршлагыг нэвтрүүлсэн байна.

Зорилт 6. Усалгаатай тариаланг түшиглэсэн, төмс, хүнсний нарийн ногооны аймаг сумын хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Боригдойн тариалалтын хэмжээг нэмэгдүүлж үр тариа, жимс жимсгэнэ, хүнсний нарийн ногоо, малын тэжээл тариалах зэргээр эдийн засгийн эргэлтэнд оруулах
2. Өрхийн тариаланг хөгжүүлж, техник тоног төхөөрөмжөөр хангах
3. Газар тариалангийн салбарт орчин үеийн өндөр хүчин чадалтай техник, технологи нэвтрүүлж, Боригдойн услалтын системийг засварлаж хүнсний ногооны төрөлжсөн зоорь, аж ахуйг хөгжүүлэх
4. Атаршсан талбайг сэргээн үр тариа, малын тэжээл тариалах замаар эдийн засгийн эргэлтэд оруулж, ургацыг эрсдлээс хамгаалах бодлогыг хэрэгжүүлж, даатгалын системд хамруулах
5. Арцны тариалалтыг судлан хөгжүүлэх, эрт ургацын хүнсний ногооны тариалалтыг хөгжүүлэх

Хүрэх үр дүн: Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэний сумын хэрэгцээг хангаж, орон нутгийн хөрсөнд тохиромжтой хүнсний нарийн ногооны таримлын сорт, төрлүүдийг нутагшуулах замаар сумын хэрэгцээт үрийг хангана.

2.5. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ

Зорилт 1. Хот байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх замаар орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Сумын төвийн “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”г боловсруулж хот байгуулалтын үндэс суурийг тавина.
2. Сумын төвийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын инженерийн шугам сүлжээ, авто болон явган хүний зам, амралт чөлөөт цагийн талбай, замын гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерийн суваг, гэр хорооллуудын гудамж талбайн хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг сумын онцлогт тохируулан боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ.
3. Сумын төвд цэвэр усны болон ариутгах татуургын нэгдсэн байгууламж, дулааны төвлөрсөн системийг бий болгон, аж ахуйн нэгж, айл өрхийг холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.

4. Сумын төвд нийтийн орон сууцтай болгон гэр хорооллын хувийн орон сууцтай айл өрхүүдийг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох нөхцөлийг бүрдүүлнэ.
5. Бүрд сумын төвийг улсын чанартай хатуу хучилттай авто замтай холбох ажлын зураг төсвийг боловсруулан, барьж эхлэнэ.
6. Сумын төвийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын орчин үеийн эко хотхоны болон монгол үндэсний уран барилгын үзэл баримтлалаар хөгжүүлэх бодлого баримтлана.
7. Суманд чөлөөт интернэтийн орчинг бий болгож, бүх багуудыг үүрэн холбооны сүлжээтэй болгох.
8. Шинээр байгуулах гэр хорооллын дэд бүтцийг шийдвэрлэх төсөл хэрэгжүүлж эхлэх
9. Сумын төвд ногоон байгууламж, дурсгалын баримал бүхий төв талбай, хүүхдийн тоглоом бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

Хүрэх үр дүн: Сумын төвийн дэд бүтэц сайжирч, цэвэр бохир дулааны шугам сүлжээнд байгууллага, айл өрхийг холбосон эко хотхон хөгжих эхлэл тавигдсан байна.

ГУРАВ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

САЛБАРЫН ЗОРИЛГО: Эрүүл мэнд, боловсрол, соёл, урлагийн ёс зүйт үйлчилгээг чухалчилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, нийгмийн хамгааллыг зорилтот бүлгүүдэд чиглүүлж, гэр бүлийг дэмжсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1. ЭРҮҮЛ МЭНД

Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагуудын тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Сумын ЭМТөвийн хүчин чадлыг нэмэгдүүлж, орчин үеийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр бүрэн хангах.
2. Сумын Эрүүл Мэндийн Төвийн эмч нар сувилагчдын ур чадварыг дээшлүүлж, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулах
3. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, архины хэрэглээг багасгах, хорт зуршлыг арилгах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил төрийн бус байгууллагыг дэмжиж ажиллана.
4. Сумын Эрүүл Мэндийн Төвийн үйл ажиллагааг нөхөн сэргээх, эмийн бус эмчилгээний чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлэх
5. Багийн эмч нарын үйл ажиллагааг сайжруулж, өдрийн болон гэрийн эмчилгээ, асаргаа сувилгаа, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээ хийхэд дэмжлэг үзүүлнэ.
6. Багийн эмч нарын ажиллах орчин нөхцлийг сайжруулах техник хэрэгсэл багажаар хангах
7. Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар салбар хоорондын хамтын үйл ажиллагааг зохицуулж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэд, гэр бүл, хамт олны үр дүнтэй бүтээлч харилцаа, түншлэлийг дэмжиж ажиллах
8. Архи, тамхины хэрэглээг бууруулж, элэгний хатуурал, хорт хавдраас сэргийлэх “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
9. Иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, онош тодруулах шаардлагатай иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулах

Хүрэх үр дүн: Элэг бүтэн Монгол хүн хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн байна.

Зорилт 2. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, халдварт болон халдварын бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил, төрийн бус байгууллагыг дэмжиж ажиллана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Эрүүл мэндийн сайн дурын бүлгүүд, ажилтнуудыг сургах чадавхижуулах, идэвхижүүлэх замаар эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх
2. Халдварын бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж буй иргэн, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагуудад бүх талын дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах

3. Халдварт өвчин, ялангуяа бэлгийн замаар дамжих халдварт /ХДХВ/ДОХ/БЗДХ/ өвчнөөс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авах замаар өвчлөлийг бууруулах

Хүрэх үр дүн: Халдварын болон халдварын бус өвчлөлийн тоог суурь түвшингээс бууруулна.

Зорилт 3. Эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, эмч нарын ур чадварыг дээшлүүлж, эмчилгээ үйлчилгээ авах шат дамжлага цөөрүүлж, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн ачааллыг бууруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын нэгдмэл удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, тусламж, үйлчилгээний уялдаа холбоо, хүртээмж, тасралтгүй байдлыг хангаж, удирдлагын баг, удирдах ажилтныг сургаж хөгжүүлэх
2. Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах
3. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогыг шинэчилж, хэрэгжүүлэх
4. Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Эмнэлгийн ажилтны хөгжлийн төв”-ийг түшиглэн эмнэлгийн мэргэжилтний мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэх сургалтад эмч мэргэжилтнийг хамруулах
5. Эрүүл мэндийн төвийг эмнэлгийн хог хаягдлыг устгах тоног төхөөрөмжөөр хангах

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн төвийг орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр бүрэн ханган, гадагш явж эмчлүүлэгчдийн тоог бууруулна.

Зорилт 4. Сумдын эрүүл мэндийн төвүүдийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Сумын эмнэлгийг мэргэшсэн эмч, мэргэжилтнээр ханган, анхан болон лавлагаат шатны тусламж үйлчилгээг хослуулан үзүүлэх
2. Эрүүл мэндийн төвийн лабораторын хүчин чадлыг нэмэгдүүлж, тэдгээрт гадаад хяналтыг хэрэгжүүлэн, лабораторийн шинжилгээний хариуг харилцан зөвшөөрдөг тогтолцоог хэрэгжүүлэх
3. Сумын эрүүл мэндийн төвийн гүний худгийн асуудлыг бүрэн шийдвэрлэх
4. Хуваарийн дагуу эрүүл мэндийн төвийн авто машины шинэчлэлтийг хийх, багийн эмч нарыг унаажуулах

Хүрэх үр дүн: Анхан болон лавлагаат шатны тусламж үйлчилгээний хүчин чадал нэмэгдэж, төрөх, хүүхэд, мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлдэг болсон байна.

Зорилт 5. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Эх, хүүхдийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, чанар, аюулгүй байдлыг хангасан, нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээний технологийг нэвтрүүлэх
2. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүүхдийн өвчний цогц менежмент болон эх, хүүхдийн эрүүл мэндэд чиглэсэн стратеги, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх, “Эх хүүхдэд ээлтэй” үйлчилгээг нэвтрүүлэх

Хүрэх үр дүн: Жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтыг 100.0 хувь, нялхасын эндэгдлийн түвшинг 0 промилд хүргэнэ.

Зорилт 6. Хүн амын дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, үр дүнтэй, аюулгүй эм зүйн тусламж, үйлчилгээг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Хүн амын дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, антибиотикийн төрлийн эмийг эмчийн жороор олгох соёлыг бүрдүүлэх
2. Эмийн эргэлтийн сангуудын менежментийн хувьчлалд хяналт үнэлгээ хийж, хувийн хэвшлийн хэлбэрээр хөгжүүлэх
3. Хувийн хэвшлийн эмийн сангуудад хяналт үнэлгээ, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах

4. Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнээр үйлчилдэг эмийн жагсаалтыг нийтийн хэрэглээ болгож хэвшүүлэх

Хүрэх үр дүн: Антибиотикийг эмчийн жороор олгож хэвшсэн байна.

3.2. БОЛОВСРОЛ

Зорилт 1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, иргэдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг чанартай зохион байгуулан, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлж цэцэрлэгийн насны хүүхдийн хамран сургалтыг 90 хувьд хүргэнэ.
2. Ерөнхий боловсролын сургуулиудын хамрах сургалтыг нэмэгдүүлэх талаар тусгай бодлого хэрэгжүүлж ажиллана

Хүрэх үр дүн: Боловсролын байгууллагуудын орчин нөхцөл сайжирч, сургалтын чанар, хүртээмж дээшлэн, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 90.0, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт сумандаа 60% тойргийн дүнгээр 99.5 хувьд хүрсэн байна.

Зорилт 2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын сургалтын болон үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. ЕБС-ийн сургуулийн дээвэр засварлах, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байранд их засвар хийх
2. Багш сурагчдын ширээ сандлыг шинэчлэж орчин нөхцлийг сайжруулна.
3. Мэдээлэл зүйн танхимыг шинэчлэн тохижуулна
4. Технологийн хичээлийн танхимын орчин нөхцлийг сайжруулна
5. Номын сангийн орчин нөхцлийг сайжруулна
6. Цэцэрлэгийн багш нарыг хэвлэх төхөөрөмжөөр хангах
7. СӨББ-ийн хүүхдийн суралцах ая тухтай орчин бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Сургууль, цэцэрлэгийн барилгуудын засвар бүрэн хийгдэж, үйлчилгээний орчин нөхцөл сайжирч, шаардлага хангасан сургалтын кабинетийн тоо нийт анги танхимын 70.0 хувьд хүрсэн байна.

Зорилт 3. Суралцагчийг бие даан, бүтээлчээр суралцахууд суралцах боломж олгох, цаашид дээд болон мэргэжлийн боловсрол эзэмшихэд бэлтгэх зорилгоор сургалтын хөтөлбөрийг сурагчдад сонголт хийх боломжтойгоор хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Хүүхэд, залуучуудын сэтгэн бодох, техникийн сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудад робот, оюуны спортын сургалт зохион байгуулахад шаардагдах сургалтын орчин бүрдүүлэн, зарим сургуулийн ахлах ангиудыг эх хэл, байгалийн ухаан, техник технологи, гадаад хэл, нийгмийн ухаан, спорт, урлагийн боловсрол олгох зэрэг төрөлжсөн хэлбэрээр хөгжүүлэх
2. Сурагчдын дунд зохион бүтээх техникийн сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр уралдаан тэмцээн зохион байгуулж хэвшинэ

Хүрэх үр дүн: Суралцагчид техник, технологи, спорт, урлагийн чиглэлээр төрөлжиж, боловсрол эзэмших боломж бүрдсэн байна.

Зорилт 4. Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, хүүхдэд ээлтэй сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Боловсролын байгууллагуудыг цахим тоног төхөөрөмж, ухаалаг самбар, техник, хэрэгсэл, хатуу, зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмж, тоглоом наадгайгаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх

2. Сургууль, цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан эрүүл ахуй, ариун цэврийн байгууламжтай болгож, “Хүүхдэд ээлтэй сургууль, дотуур байр” хөтөлбөр хэрэгжүүлэх
3. Ерөнхий боловсролын сургуулиудыг спорт, хөлбөмбөгийн талбайтай болгох
4. Сургууль, цэцэрлэгүүдийг интернэт сүлжээнд бүрэн холбох

Хүрэх үр дүн: Сургууль, цэцэрлэгүүдэд хүүхдийн сурах орчин, техник хангамж бүрдсэн байна.

Зорилт 5. Хүүхдийн авьяас, ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах бодлого баримтлан ажиллана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Хүүхэд, залуучуудыг бүтээлч сэтгэлгээтэй, шийдвэр гаргах, хамтарч ажиллах чадвартай, үндэсний хэл, соёл, уламжлалаа эрхэмлэдэг иргэн болгон төлөвшүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий “Оюунлаг Өвөрхангай” аймгийн дэд хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
2. Оюуны спортыг хөгжүүлэх зорилгоор “Шатар” аймгийн дэд хөтөлбөр, бусад урлаг спортын хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэх
3. Сурагчдын зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэднийг хөдөлмөрт суралцуулах, хамтарч ажиллах чадвар эзэмшүүлэх, англи хэлний сургалтыг дэмжих, урамшуулах зорилгоор “Англи хэлний вакум сургалттай хөдөлмөр амралтын явуулын зуслан”-г шинээр бий болгох
4. Төрийн болон төрийн бус байгууллага, хүүхдийн өөрөө удирдах байгууллагын хамтын ажиллагааг сайжруулж, сурагчдын дунд буй үе тэнгийнхний дарамтыг таслан зогсоох
5. Зорилтод бүлгийн хүүхдүүдийн боловсролын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Боловсролын олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, дэмжин ажиллах

Хүрэх үр дүн: “Оюунлаг Өвөрхангай”, “Шатар” хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоог нийт суралцагчдын 70 хүртэл хувьд хүргэсэн байна.

Зорилт 6. Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгох, тэдний нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд анхаарч ажиллана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Багшийн ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчний нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний эрүүл мэнд, хөдөлмөрийн үнэлэмж, орон байрны нөхцөлийг сайжруулах, багш нарын арга зүйн хөгжлийг дэмжих, тэргүүн туршлага, ур чадвараа түгээн дэлгэрүүлэх боломжийг олгох зорилго бүхий “Багшийн хөгжил” аймгийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх
2. Багш боловсон хүчний мэргэжил, боловсрол, ур чадварыг дэмжсэн “Бүтээлч багш” хөтөлбөрийг хэрэгжүүлж, гадаад дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, тэдний орон сууцны хангамж, цалин хөлсийг нэмэгдүүлэх бодлого гарган хэрэгжүүлнэ.
3. Боловсрол, соёл, урлагийн салбарын гадаад, дотоод харилцааг өргөжүүлэн хөгжүүлж, жил бүр 2 хүртэлх багш, уран бүтээлчид, удирдах ажилтнуудыг гадаадад, 5 хүртэлх багшийг дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалт, аялалд хамруулах
4. Амжилттай ажиллаж буй багш сурагчдыг урамшуулах журам боловсруулж хэрэгжүүлэх
5. Багш сурагчдыг уламжлалт аймаг улсын хэмжээний уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн: Багш нарын ажиллах, амьдрах орчин нөхцөл сайжирч, сургуулийн арга зүй технологийн санд 15 хүртэл хичээл, арга зүйг бүртгэн авч, 8 -аас доошгүй багш, уран бүтээлчдийг гадаад оронд мэргэжил дээшлүүлэх чиглэлээр туршлага судлуулсан байна.

Зорилт 7. Бүх нийтийн боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар менежментийг дээшлүүлж, орон нутгийн захиргааны байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэн, “Насан туршийн боловсролын төв болон нэгж”-үүд нь хүн амын насан туршийн боловсролыг дэмжигч, мэдээлэл түгээгч байх боломж нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Сумын насан туршийн боловсролын нэгжийг иргэний танхимтай хамтран ажиллуулж, багш арга зүйчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшүүлэх
2. Сургууль завсардсан болон сургуульд огт элсэн суралцаагүй хүүхэд, залуучуудыг “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөр”-ийн сургалтад хамруулах замаар

боловсрол нөхөн олгох, ерөнхий боловсролын сургуульд шилжүүлэн суралцуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах

3. Насан туршийн боловсрол олгох сургалтыг бизнес-амьдрах ухааны, ёс суртахуун-төлөвшлийн, гоо зүйн, гэр бүлийн, байгаль орчны, иргэний боловсрол /эрх зүй, эрүүл мэнд, гамшгаас хамгаалах/ олгох гэсэн чиглэлээр сургалтын олон талт хэлбэрээр зохион байгуулах

Хүрэх үр дүн: Сургууль завсардсан болон сургуульд огт элсэн суралцаагүй хүүхэд, залуучуудын тоог бууруулж, “Насан туршийн боловсролын төв болон нэгж”-үүдийн үйл ажиллагаанд хамрагдагсдын тоо суурь түвшинээс ахисан байна.

3.3. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

Зорилт 1. Соёл, урлагийн байгууллагын материаллаг бааз, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөдөөгийн иргэдэд үзүүлэх зайны болон нүүдлийн үйлчилгээг өргөжүүлэн, соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын үйлдвэрлэлийг дэмжиж, соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Соёл, урлагийн байгууллагуудыг хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахын зэрэгцээ энэ чиглэлд гадаад, дотоодын хөрөнгө оруулагч байгууллагуудтай хамтран ажиллах
2. Соёлын төвийн үйлчилгээг тогтмолжуулж орлогыг нэмэгдүүлэх
3. Сумын соёлын төв, спорт зал, номын сангийн барилгад их засвар хийх, гадна талбай, хайс хашлагыг шинэчлэх, соёл, урлагийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах
4. Спорт залны сандал техник хэрэгслийг шинэчлэх
5. “Өвөрхангайн соёлын өдөр” арга хэмжээг сумандаа зохион байгуулж, нүүдлийн ном, соёлын үйлчилгээг хэрэгжүүлэх
6. Хувь хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгийг хөгжүүлэхүйц соёл, урлагийн шинэлэг ажлыг орон нутагт хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, “Соёлын үйлдвэрлэл” аймгийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх
7. Соёл, урлагийн нэгдсэн арга хэмжээ, уралдаан, наадам зохион байгуулах замаар хүүхэд залуучууд, ардын авьяастнуудын авьяас билгийг хөгжүүлэх
8. Сум, аймгаас төрж гарсан алдартнуудыг урих, сонгодог болон жүжгийн урлагын үйлчилгээг орон нутгийн иргэддээ үзүүлэх
9. Соёлын төвийг Ардын жүжигчин Ч.Долгорсүрэнгийн нэрэмжит болгох ажлыг санаачлан эхлүүлэх
10. Үндэсний бүх төрлийн хөгжим болон морин хуур, уртын дуу, ардын болон цэнгээнт, спорт бүжгийн дугуйланг хичээллүүлэх, яруу найраг болон бүжиг сонирхогчдын клуб байгуулж ажиллуулах
11. Номын сангийн фондийн баяжилтын ажлыг жил бүр хийх тэргүүний уншигч гэр бүл, хүүхэд, залуучуудыг шалгаруулах ажлыг тогтмолжуулах
12. Үндэсний бичиг соёлын өдрийн арга хэмжээг өргөжүүлэх
13. Ардын уран зохиолч, Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт яруу найрагч Д.Пүрэвдоржийн төрсөн өдрөөр хүүхдийн дунд яруу найргийн тэмцээн зохион явуулж хэвших, түүний 85 жилийн ойгоор яруу найрагчдийн дунд яруу найргийн наадам зохион явуулах
14. Нүүдлын номын санг дэмжих, хуучин номын худалдааны цэгтэй болох
15. Хөгжим, бүжгийн багш бэлтгэдэг их, дээд сургуультай хамтран ажиллаж, орон нутагт элсэлт зохион байгуулах, мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах замаар сумдын соёлын төвүүдийн мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлж ажиллах
16. Мэргэшсэн, мэргэжлийн ангийн багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх замаар уран бүтээлчид, соёл, урлагийн ажилтнуудыг чадавхижуулах
17. Соёлын ажилтнууд, уран бүтээлчдийг хөрш зэргэлдээ болон бусад улсад туршлага судлуулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалтанд хамруулах
18. Соёл, урлагийн ажилтны ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхүйц хэрэгцээт соёл, урлагийн үйлчилгээг зохион байгуулах

Хүрэх үр дүн: Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний орчин нөхцөл сайжирч, соёлын байгууллагууд мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдан, орон нутгийн онцлогтой соёл, урлагийн арга хэмжээ тогтмолжсон байна.

Зорилт 2. Соёлын биет болон биет бус өв, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалах, хамгаалах, сурталчилах ажлыг сайжруулан, иргэд, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Музей, сумын орон нутаг судлах танхимыг засварлан, үзүүлэг дэглэлтийг шинэчилж, үйл ажиллагааг нь өргөжүүлэн, соёлын өвийн боловсрол олгох ажлыг ЕБС, СӨББ болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулж, соёлын өв сурталчлах төв болгох
2. Төв халхын уртын дуу, морин хуурын сургалтыг өргөжүүлэн уралдаан, наадам зохион байгуулах, шавь сургалтыг хөгжүүлэх замаар төв халхын болон орон нутгийн онцлогтой биет бус өвийг бүртгэн баримтжуулах, хамгаалах, сурталчлан түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх ажлыг зохион байгуулах
3. Иргэдтэй түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалж, хамгаалах, урамшуулал олгох журам гарган, иргэд, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх
4. Музей, цэцэрлэг хүрээлэн, хийдийн хашааг нэгтгэн сайжруулах
5. Дашравжаалан хийдийн орчин нөхцлийг сайжруулж байнгын ажиллагаатай болох

Хүрэх үр дүн: Музейн үйлчлүүлэгчдийн тоо болон орлого нэмэгдэж, соёлын биет болон биет бус өв, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалт сайжран, хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

Зорилт 3. Нийтийн биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өргөжүүлж, биеийн тамир, спортыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх танхимын үйл ажиллагааг дэмжин, дугуйн замыг шинээр бий болгоно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Сум, байгууллага, аж ахуйн нэгжүүд ажиллагсадын хэрэгцээ шаардлагад нийцсэн нийтийн биеийн тамирын талбай, чийрэгжүүлэх танхим, ногоон байгууламж бүхий гүйлт, алхалтын зам, талбай байгуулах, сэргээн тохижуулах ажлыг өрнүүлэх
2. Суманд дугуйн унах хөдөлгөөн өрнүүлж, дугуйн замтай болох
3. Тамирчдын орон нутагтаа бэлтгэл сургуулилт хийх бэлтгэх орчин нөхцлийг сайжруулах
4. Сагсан бөмбөг, ширээний теннис, үндэсний сур, самбо, жудо, чөлөөт бөх, шатар, волейбол, хөл бөмбөг, цана, үндэсний бөх, хөнгөн атлетикийн шигшээ багийг түлхүү хөгжүүлэн багийн болон оюуны спортыг дэмжин, олимпийн төрлийн спортыг тэргүүлэх чиглэл болгож хөгжүүлэх

Хүрэх үр дүн: Сум, орон нутаг, байгууллага, хамт олонд эрүүл амьдралын орчин нөхцөл бүрдэж, нийтийн биеийн тамир хөгжин, аймгийн шигшээ багийн тамирчдын амжилт нэмэгдсэн байна.

Зорилт 4. Спортын сонирхчдийг дэмжин, тамирчдын залуу халааг бэлтгэж, бүсийн чанартай тэмцээнийг тогтмол зохион байгуулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Өсвөрийн шигшээ багуудын үйл ажиллагааг дэмжин, спортыг орон нутагт хөгжүүлэх
2. Жилд 1-2 удаа бүсийн чанартай уралдаан тэмцээн зохион байгуулах, тамирчдыг тэмцээнд оролцох нөхцөл боломжоор хангах

Хүрэх үр дүн: Өндөр зэрэглэлтэй тамирчдын тоо нэмэгдэн, тэдний залгамж халаа бэлтгэгдэж, спортын төрлүүдөөр гаргасан тамирчдын амжилт, чанар өссөн байна.

3.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Зорилт 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар 200 аас доошгүй ажлын байр бий болгоно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 300.0 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй болгох
2. “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг шинээр боловсруулж, зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг ногоон ажлын байрыг бий болгох санал санаачилгатай уялдуулж хэрэгжүүлэх
3. Шинээр ажлын байр олноор бий болгосон, тогтвортой үйл ажиллагаа явуулж ажлын байраа хадгалан сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого баримтлах
4. “Нэг өрх – Нэг ажлын байр” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн 200 –аас доошгүй ажлын байрыг бий болгож, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

Зорилт 2. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах, ажилд зуучлах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөрийн харилцааг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Ажил мэргэжлийн мэдээллийн танхим байгуулж үйл ажиллагааг өргөжүүлэн ажилгүй иргэд, суралцагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх, ажилд зуучлах үйлчилгээнд хамруулах
2. Мэргэжлийн сургуулиудтай хамтран ажиллах, мэргэжлийн танилцах аялал зохион байгуулах зэргээр мэргэжлийн сонголт хийхэд нь зөвлөн туслах
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах чиглэлээр нийгмийн түншлэлийн байгууллагатай хамтран ажиллах
4. Хөдөлмөрийн хөлсний бүрэн олголтын байдалд хяналт тавих чиглэлээр орон тооны бус зөвлөл байгуулан ажиллуулах

Хүрэх үр дүн: Ажилд зуучлагдсан, зөвлөгөө мэдээлэл авсан хүний тоо суурь түвшнээс 2 дахин нэмэгдсэн байна.

3.5. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛ

Зорилт 1. “Хүүхдэд ээлтэй аймаг” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж, хүүхдийн хүмүүжил төлөвшилд анхаарч, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. “Хүүхдэд ээлтэй аймаг” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж, бүх нийтээр хүүхдийн эрхийг хүндэтгэх, хүмүүжил төлөвшилд нь анхаарах, хүүхдийн амьдрах, хөгжих, нийгэмших орчныг сайжруулахад төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэд, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах
2. Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон, үр бүтээлтэй өнгөрүүлэх, амьдралын зөв дадал, зуршилд сургах, мэргэжлийн чиг баримжаатай болгох зорилгоор тэдний эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн төрөл бүрийн секц, дугуйлан хичээллүүлэх, ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх, хүмүүжил төлөвшилд нь эерэгээр нөлөөлөх сургалт, мэдээллийн олон талт ажиллагаа явуулах чиглэлээр “Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв”-ийг соёлийн төвийн дэргэд байгуулах
3. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор парк, спорт тоглоомын талбайнуудын тоог нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал, хүмүүжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн тоо суурь түвшнээс 2 дахин нэмэгдсэн байна.

Зорилт 2. Хүүхэд, гэр бүлд чиглэсэн хөгжил, хамгааллын үйлчилгээний нэр төрөл, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, төр, иргэний нийгмийн байгууллагын хамтарсан сүлжээг бий болгох, хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулах
2. Эрх нь зөрчигдсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ, хүүхдийн тусламжийн утасны сүлжээг олон улсын стандартад нийцүүлэн өргөжүүлж, бат бэх гэр бүлийг төлөвшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах
3. Хүүхэд, залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулж олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

Хүрэх үр дүн: Гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийтийн эерэг ойлголт хандлага нэмэгдэж, хүүхэд, гэр бүлийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.

3.6. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Зорилт 1. Нийгмийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн өрхүүдийг оновчтой тодорхойлж, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээг чанаржуулж, салбар дундын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах
2. Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, тэдний амьдралын туршлага, мэдлэг чадварыг залуу үеийнхэнд өвлүүлэх, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ахмадуудад зориулсан амралт, чийрэгжүүлэлтийн болон чөлөөт цагийн танхим байгуулах
3. Ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрх нь зөрчигдсөн хүүхэд, эмэгтэйчүүд, хорих ангиас суллагдсан болон архины хамааралтай иргэд зэрэг зорилтот бүлгүүдэд сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг тогтмол зохион байгуулж, хувийн хэвшил, иргэд, иргэний нийгмийн байгууллагатай хамтарч ажиллах
4. Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцааг зорилтот бүлгүүдэд хүргэх

Хүрэх үр дүн: Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн тоо буурч, зорилтот бүлэгт чиглэсэн үйлчлүүлэгчдийн тоо 2 дахин нэмэгдсэн байна.

Зорилт 2. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдах боломжийг хэрэгжүүлж, нийт иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах
2. Хувийн хэвшилд ажиллагсдын эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг цалин хөлсний хэмжээгээр төлүүлэх ажлыг бүх нийтийн хэвшил болгох
3. Нийгмийн даатгалын цахим мэдээллийн санг ашиглаж, хүссэн мэдээллээ шуурхай чирэгдэлгүй авах талаар даатгуулагч иргэдэд хэвлэл мэдээллээр сургалт хийх

Хүрэх үр дүн: Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулснаар тэдний нийгмийн баталгаа хангагдаж, сэтгэл ханамж дээшилнэ.

Зорилт 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг чанаржуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний гэр бүлийг осол гэмтэл болон халдварын бус өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлийн талаар анхан шатны мэдлэгтэй болгох, нэгэнт өвчилсөн болон осол гэмтэлд өртсөн үед нөхөн сэргээлтийг гэрийн нөхцөлд хийж, хүндрэлээс сэргийлэх сургалтыг багийн эмч нараар гүйцэтгүүлэх
2. Сум, багийн эмч, багийн Засаг дарга нарыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар нэгдсэн судалгаатай болгож, эмчлэн эрүүлжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах талаар хийсэн ажлын үр дүнгээр нь урамшуулах

Хүрэх үр дүн: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тав тухтай тохилог орчинд эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үйлчилгээг авч, хүндрэл чирэгдэл багассан байна.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

САЛБАРЫН ЗОРИЛГО: Хууль нэг мөр хэрэгждэг, иргэн бүрт эрх тэгш, шударга үйлчилдэг, иргэдийн оролцоог хангасан, итгэл хүлээсэн, хүний эрхийг дээдэлсэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална.

4.1. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт 1. Төрийн албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд шаардлага хангахгүй, ёс зүйн алдаа гаргасан төрийн албан хаагчдад хариуцлага тооцож, төрийн үйлчилгээг иргэдээр үнэлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Төрийн албан хаагчдыг ажлын байранд тавигдах шаардлагын дагуу аттестатчилж, ажил үүргийн давхардал, мэргэжил, ур чадвар, ёс зүйг үнэлж, хариуцлагыг өндөржүүлэх
2. Төрийн албан хаагчийн цалин, нэмэгдлийг ажлын бүтээмж, туршлага, иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанартай нь уялдуулж олгодог зарчим нэвтрүүлэх
3. Байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг хөндлөнгийн байгууллага болон иргэд, үйлчлүүлэгчдээр үнэлүүлэх, үнэлгээний дүнг үйл ажиллагаанд ашиглах

Хүрэх үр дүн: Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага сайжирсан байна.

Зорилт 2. Сумын ИТХ, ЗДТГ-ын материаллаг бааз, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. ЗДТГ-ын барилгын засварын зураг, төслийн төсвийг хийлгэж засварын ажлыг хэсэгчлэн хийж дуусгах
2. Сумдын ИТХ, ЗДТГ-ыг шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Сумдын төрийн байгууллагуудын ажиллах орчин, нөхцөл сайжирч, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна.

Зорилт 3. Сумын хөдөөгийн зарим багуудад багийн төвийг шинээр барьж, багийн Засаг дарга нарыг унаагаар хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. 2 багийн төвийн барилгыг шинээр барих, 3 багийн төвийг засварлах
2. Багийн Засаг дарга нарыг унаагаар хангах, ажиллах нөхцөлийг сайжруулахад анхаарах
3. Хөдөөгийн багийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах

Хүрэх үр дүн: Багийн Засаг дарга нарын ажиллах нөхцөл сайжирсан байна.

Зорилго 4. Төрийн албан хаагчдыг чадавхижуулах зорилтот хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан мэдлэгийн менежмент олгоход түлхүү анхаарна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Төрийн албан хаагчдыг чадавхижуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх
2. Төрийн албан хаагчдад шинжлэх ухаан, технологийн ололт, мэдлэгийн менежментэд тулгуурлан мэргэшүүлэх, төрийн албаны мэргэшсэн, чадварлаг байх нөхцөлийг дэмжих

Хүрэх үр дүн: Төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэжүүлэх сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлсэн байна.

Зорилт 5. Багийн иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг Иргэний танхимын үйл ажиллагаатай уялдуулж, аймгийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төвтэй холбон, чиг үүргийг өргөтгөнө.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Сумын Иргэний танхимын ажиллах үлгэрчилсэн журам батлан хэрэгжүүлж, үйл ажиллагааг өргөтгөх
2. Иргэдийн өргөдөл шийдвэрлүүлэх үйл ажиллагааг хөнгөвчилөхөөс гадна судалгаа шинжилгээний үндсэн дээр бодлого тодорхойлоход иргэдийн санаа бодлыг тусгах боломжийг бий болгох зорилгоор шуурхай удирдлагын орон тооны бус зөвлөлийг байгуулах
3. Сумын Шуурхай удирдлагын орон тооны бус зөвлөлийг Иргэний танхимуудад түшиглэн байгуулж, түүнийг аймгийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангуулж ажиллуулах

Хүрэх үр дүн: Иргэдийн саналыг төрийн бодлого шийдвэрт тусгах, төрийн үйлчилгээг ил тод зохион байгуулах нөхцөл бүрдсэн байна.

Зорилт 6. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөж, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлын жагсаалтыг баталж хэрэгжүүлэх
2. Төр, хувийн хэвшлийн хамтран ажиллах зөвлөлийг байгуулж, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын саналыг орон нутгийн бодлого шийдвэрт тусгах, хамтран хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Талуудын хамтын ажиллагаа өргөжиж, итгэлцлэл нэмэгдсэн байна.

Зорилт 7. Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай болгоход чиглэсэн шинэ дэвшилтэт хэлбэрийн үйлчилгээг тууштай нэвтрүүлж, иргэдийн тавьсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг болгох, бүрдүүлэх бичиг баримтын нэр төрлийг цөөлөх, хялбаршуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Цахим хэлбэрээр олон төрлийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх
2. Төрийн үйлчилгээг үзүүлэхэд гаргадаг хүнд суртал, алдааг арилгах

Хүрэх үр дүн: Төрийн үйлчилгээнд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан, зайн үйлчилгээг нэвтрүүлж, иргэний, эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд газар дээр нь чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх боломжтой болгоно.

Зорилт 8. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналт шалгалтын нэгж ажиллуулж, тэдгээрийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнд суурилж, төрийн байгууллагуудын үйлчилгээ болон менежментийг сайжруулах
2. Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт дотоод аудит хийлгэх замаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, зөвлөн туслах үйл ажиллагааг чанаржуулах

Хүрэх үр дүн: Төрийн байгууллагуудын үйлчилгээний чанарын түвшин дээшилсэн байна.

Зорилт 9. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хийх төрийн хяналт шалгалтыг багасгаж, зөвлөн туслах үйлчилгээг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зөвлөн туслах багийг томилон ажиллуулах
2. Зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангах үйл ажиллагаанд шаардагдах материаллаг бааз, хүний нөөцийг чадавхижуулан ажиллуулах

Хүрэх үр дүн: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлж, чадавхижуулсан байна.

Зорилт 10. Төрийн байгууллагуудын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах харилцааг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчилах зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх
2. Хөдөөгийн иргэдэд орон нутгийн цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг бүрдүүлэх
3. Сумын сонинг улирал бүр гаргаж нийтийн хүртээл болгох

Хүрэх үр дүн: Хөдөөгийн иргэдэд орон нутгийн цаг үеийн мэдээллийг шуурхай хүргэх нөхцөл бүрдсэн байна.

Зорилт 11. *Орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, сумын хөгжлийг дэмжих “Стандарттай Өвөрхангай” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.*

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоо” стандартыг нэвтрүүлэх
2. Ус, дулаан, цахилгаан, эрчим хүчний хэмжлийн эталон төхөөрөмжөөр ханган, иргэдэд үйлчлэх үйлчилгээг чирэгдэлгүй болгох
3. “Стандарттай Өвөрхангай” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: *Стандартчилал, хэмжил зүйн үр дүнг иргэд хүртэх хүртээмж нэмэгдсэн байна.*

Зорилт 12. *Иргэн–цэргийн харилцааг бэхжүүлж, цэргийн насны залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил олгох төлөвшилийн орчинг бүрдүүлнэ.*

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Цэргийн насны залуучуудыг спорт, бие бэлтгэл, ажил мэргэжлийн сургалтанд хамруулах, хөдөлмөр эрхлэх бэлтгэл сургуулалт хийлгэх
2. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн анхан шатны сургалт зохион байгуулах, тэднийг орон нутгийн бүтээн байгуулалтанд оролцуулах

Хүрэх үр дүн: *Сургалтын чанар сайжирч, цэрэг, эх оронч хүмүүжил төлөвшсөн байна.*

4.2.ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Зорилт 1. *Иргэдийн нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг иргэд, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулж, хууль зүйн туслалцааны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.*

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Төрийн бүх шатны байгууллагуудад “Эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөө”-г жил бүр шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх
2. Нийгмийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж, эрх зүйн хөтөч ажиллуулах

Хүрэх үр дүн: *Эрх зүйн сургалт, сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.*

Зорилт 2. *Хүний эрхийг дээдлэх Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенци, хууль тогтоомжоор баталгаажсан зарчмыг хэрэгжүүлж, хүний эрхийн асуудлаар нутгийн захиргааны болон олон нийтийн байгууллага, иргэдээс гаргасан санал санаачилгыг дэмжиж, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулна.*

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Хүний эрхийн боловсрол, мэдээллийг олон нийтэд түгээх замаар нийгмийн бүлгүүдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах
2. Хүний эрхтэй холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хөндлөнгийн хяналт тавих ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх
3. Хүний эрх, эрх чөлөө, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхолд харшилсан шийдвэр гаргагчдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх
4. Бизнесийн шударга өрсөлдөөний эрүүл орчныг бүрдүүлэн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилтот арга хэмжээг жил бүр зохион байгуулах

Хүрэх үр дүн: *Орон нутагт гарч байгаа хүний эрхийн зөрчил, гомдлыг шуурхай шалгаж шийдвэрлэсэн байна.*

Зорилт 3. *Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хариуцлагын тогтолцоог бий болгоно.*

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Байгууллага бүр авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр шинэчлэн, тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, зардлыг тусгайлан төлөвлөж, санхүүжүүлдэг болгох

2. Авлига, хүнд суртлыг бий болгоход нөлөөлж буй холбогдох дүрэм журмыг хялбарчлах, хүчингүй болгох зэрэг арга хэмжээ авч, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хэрэглэгчдээр үнэлүүлэх ажлыг хэвшүүлэн, үр дүнг тооцож ажиллах
3. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулж, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх

Хүрэх үр дүн: Авлигын эсрэг стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар авлигын индексийг 80-аас доошгүй хэмжээнд хүргэнэ.

Зорилт 4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, нийгмийн хэв журмыг хангахад хуулийн байгууллагуудын хамтын хүчин чармайлтыг чиглүүлж, гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлийг судлаж, нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. “Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээг эрчимжүүлэн, архины хэрэглээг багасгах, хорт зуршлыг арилгах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагуудыг дэмжин ажиллах
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болон бусад тодорхой төрлийн гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлөөс хамааран зорилтод ажлыг жил бүр төлөвлөж хэрэгжүүлэх
3. Малчдын бүлэг, нөхөрлөлийг холбооны болон бусад техник хэрэгслээр хангах, мал бүрийг коджуулах замаар мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх
4. СГХУСАЗЗөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж, олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх
5. Цагдаагийн хэсэгтэй хамтран ажиллаж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
6. Олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах ажлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, орон байрны хулгайн гэмт хэргийг илрүүлж, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа олон нийтийн зөвлөл, нөхөрлөл, бүлгэмийн үйл ажиллагааг бүх талаар дэмжин ажиллах

Хүрэх үр дүн: Гэмт хэргийн гаралтыг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

4.3. ОНЦГОЙ БАЙДАЛ

Зорилт 1. Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг сурталчилах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, аврах бүлэг, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын сургалт, дадлагыг тогтмолжуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг сурталчилах ажлыг тогтмолжуулж, сумын Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулах
2. Гамшгаас хамгаалах команд штабын сургалт, дадлагыг зохион байгуулах
3. Байгууллага бүр гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй болох

Хүрэх үр дүн: Байгууллага, аж ахуйн нэгж, иргэд гамшгаас хамгаалах арга хэмжээнд дадлагажиж, аврах бүлэг, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын чадвар дээшилсэн байна.

Зорилт 2. Гал унтраах болон аврах машин техник, багаж хэрэгслийн парк шинэчлэлтийг дэс дараатайгаар шийдвэрлэж, сумдад ой хээрийн түймэр унтраах багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Онцгой байдлын бэлтгэл, бэлэн байдлыг хангах, гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлж, техник хэрэгслийн хангалтыг сайжруулах
2. Хээрийн түймэр гарах эрсдэлтэй саруудад урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, ой, хээрийн түймэр унтраах багаж хэрэгслэлтэй болгож, бэлэн байдлыг хангах
3. Сумын Засаг даргын Нөөцийн санд болзошгүй цагийн байдлын үед хэрэглэх эх үүсвэрийг жил бүр төлөвлөх

Хүрэх үр дүн: Гамшигийн үед ажиллах бэлэн байдал хангагдсан байна.

Энэхүү сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “ЭКО БҮРД”-2020” хөтөлбөр нь 4 бүлэг, 63 зорилт 273 арга хэмжээтэй байна.

ТАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Засаг дарга, түүний Тамгын газрын шууд удирдлагаар салбарын байгууллагын дарга удирдлага ЗДТГ-ын мэргэжилтнүүд чиг үүргийн дагуу гүйцэтгэнэ.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг жил бүр сумын Засаг даргын Тамгын газар иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, иргэдэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

Хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хуулийн хугацаанд Аймгийн Засаг Даргын Тамгын газарт хүргүүлж ажиллана.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, иргэд, олон нийтийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

--- 000 ---